




Нэг хүнд ноогдох ДНБ(2018)

Нэг хүнд ноогдох ДНБ(2018)

Монголын ДНБ өсөлт(хувь)



Эх сурвалж: United Nations

Эх сурвалж: United Nations

Эх сурвалж: YCX


Монгол улсын нэг хүнд ноогдох ДНБ-ээр Дэлхийд 112-р байранд Азид 27-р байранд ордог(*tradingeconomics.com*). Нэг хүнд ноогдох ДНБ дэлхийн дундаж 11,000 доллар байдаг бол хөгжиж буй орнуудын дундаж 5,700 доллар байдаг(*United Nations, World Economic Situation and Prospects*). Харин Монгол улсынх 4,198 доллар байна.

2008 оны дэлхий нийтийг хамарсан санхүү эдийн засгийн хямралын нөлөөнөөс хамаарч манай эдийн засгийн бодит өсөлт 2009 онд -1.3 хувь болж унасан хэдий ч 2008-2011 онд эдийн засгийн бодит өсөлт 7.8 хувь байсан. 2013 онд 11.6 хувийн өсөлт олон улсад маш өндөр өсөлттэй оронд тооцогдож байсан. Гэвч дэлхийн эдийн засгийн хямрал, түүний дотор олборлох салбарын түүхий эдийн үнийн уналт болон уул уурхайн томоохон ордуудын орлогыг бууруулсан ба төсвийн зардлаа зээлээр нөхсөнөөр Монгол улсын эдийн засаг хүндрэн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2016 онд 1.2 хувь хүртэл буурсан.

Олон улсын зах зээл дээр олборлох салбарын түүхий эдийн үнийн өсөлт манай орны эдийн засгийн байдал эерэг нөлөөлөл үзүүлж байгаа ба энэ оны эхний улирлын байдлаар 8.6 хувь өссөн гэж мэдээлсэн. Энэ өсөлтийн гол шалтгаан нь Оюу толгойн зэсийн агууламж нэмэгдэж, орлого нь 43 хувиар өссөнтэй холбоотой. Уул уурхайн салбар эдийн засгийн хорь гаруй хувийг дангаараа эзэлдэг. Дэлхийн банкны таамаглалаар нүүрсний зах зээлийн үнэ жилд дунджаар 4 хувиар унана гэсэн таамаглал гаргасан нь манай улсын хувьд сайн мэдээ биш. Гэхдээ сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтөнд эзлэх хувь бага зэрэг буурсан дүр зураг ажиглагдаж байгаа. Энэ нь эдийн засаг төрөлжиж буй дохио гэж харж болно.


Хэдий эдийн засгийн өсөлт өндөр хувьтай байгаа ч иргэдийн бодит амжиргаанд хүртээмж муутай байгаа нь ажиглагдаж байна. 2018 оны эцсээр иргэдийн бодит орлого өссөн ч зарлага нь дагаж нэмэгдсэн. Учир нь инфляцын өсөлт зарлагыг мөн өсгөсөн.

Уул уурхайн олборлолт ДНБ-д эзлэх хувь





Эх сурвалж: YCX

World Bank Australian Coal Price Forecast



Эх сурвалж: World bank



Эх сурвалж: INTERNATIONAL MONETARY FUND

Дэлхийн хөгжингүй орнуудын инфляцын түвшин 0%-3% хооронд байдаг. Харин манай улсын хувьд 2018 оны эцсээр 8.1 хувь байсан. Манай улс инфляцын түвшингээр дэлхийд 25-р байранд, эдийн засгийн өсөлтөөр 22-р байранд жагсаж байна.(International Monetary Fund, World Economic Outlook(April 2019))

Монгол улсын инфляцын түвшин 2015 онд 1.9 хувь, 2016 онд 1.0 хувь болтол буурч байсан нь дэлхийн эдийн засгийн хямрал, олборлох салбарын түүхий эдийн уналтаас болж Монгол улсын эдийн засгийн байдал муудаж эрэлтийн чанартай инфляц буурсан нь нөлөөлсөн. 2017 онд 6.4 хувь болж 2019 оны 2-р улирлаар 7.9 хувь болж өссөн.

Тэгэхээр бидний орлого өсөөгүй бол худалдан авах чадвар 7.9 хувиар буурсан гэсэн үг. 2019 оны инфляцын түвшин 8.5 хувь байна гэж Азийн хөгжлийн банк таамаглал гаргасан ба гол шалтгаан нь төсвийн 2019 оны төсвийн зардал өндөр байгаатай холбоотой. Төв банк инфляцыг барихын тулд бодлогын хүүг нэмэгдүүлэх магадлалтай. Ингэснээр арилжааны банкнуудын зээлийн хүү нэмэгдэж мөнгөний эргэлт багассанаар эдийн засгийн бүтээмж буурч эдийн засаг удааших хандлагатай байдаг.

2009 оны 3-р сарын 11 өдөр бодлогын хүүг 9.75 хувиас 14 хувь хүртэл нэмэгдүүлсэн. Энэ үед манай эдийн засгийн өсөлт хасах хувьруу орсон байсан ба энэ үед инфляц 4.2 хувь хүртэл буурсан. 2010 оноос түүхий эдийн үнэ нэмэгдэж эдийн засгийн байдал сайжрах үед бодлогын хүүг аажмаар нэмсэн. Үүний шалтгаан нь эдийн засагт халалт үүсч иргэдийн эрэлт хэрэгцээний өсөлтийг дотоодын нийлүүлэлт шууд хангаж чадахааргүй болсноор бараа болон үйлчилгээний үнэ нэмэгдэж байсантай холбоотой.




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо




Эх сурвалж: Монгол банк

ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙТ ҮНЭЛГЭЭ




2019 оны 6 сарын байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХК-ийн хувьцааны зах зээлийн үнэлгээ 2,601 тэрбум төгрөгт хүрсэн. 2013 оноос хойш зах зээлийн үнэлгээ 55 хувиар өссөн мэт харагдаж байгаа боловч нийт зах зээлийн үнэлгээг доллараар үнэлвэл 2.8 хувь унасан харагдаж байна.

S&P 500 Shiller PE ratio




2019 оны 8 сарын байдлаар S&P 500 индекст байгаа компаниудын дундаж PE харьцаа 28.4 байна. Харин манай улсын топ-20 индекст байгаа компаниудын дундаж PE харьцаа 19.43 байгаа ба (2018 оны цэвэр ашгаас тооцсон) энэ S&P 500 индекст байгаа компаниудын түүхэн дунджаас өндөр байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АРИЛЖААНД ЭЗЛЭХ ХУВЬ



2012 он хүртэл гадаадын хөрөнгө оруулагчдын арилжаанд орох хэмжээ өсөж байсан ба 2013 оноос эхлэн эдийн засгийн нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал зэргээс хамаарч гадаадын хөрөнгө оруулагчдын арилжаанд орох хэмжээ эрс буурсан. Энэ үед төгрөгийн ханш хурдацтай унаж байсан нь нөлөөлсөн. Учир нь үнэт цаасны арилжаанд зөвхөн дотоодын мөнгөн дэвсгэртээр буюу төгрөгөөр оролцох боломжтой байдаг ба энэ нь гадны иргэдийг ханшийн эрсдэлд оруулж байдаг.

АРИЛЖААНЫ ДҮН(Сая төгрөг)



2015 оноос үнэт цаасны арилжааны дүн огцом нэмэгдсэн ба үүний шалтгаан нь ЗГҮЦ гарж арилжааны 90 орчим хувийг эзэлж байсан. 2018 оны 1-р сараас хойш өдрийн дундаж арилжааны дүн 750 сая төгрөг байна.